



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/141/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: Munguntsetseg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР**

Утас: 77117 4444 / Факс: 77117 2222
Телефон: 77117 4444 / Факс: 77117 2222
Тайвч: darhan@adga.mn

2022.12.23 36 №
ТӨСВИЙН АУДИТЫН АЖЛААНЫ ДЭД АЖЛААНЫ ТАЙЛАН

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАЯСГАЛАНМӨНХ ТАНАА



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний дүгнүүлсэн хангалттай бөгөөд эсхистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв багтаж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ өнгөд эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүнлэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АШУУИС-ийн дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР



009079111

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,385.2	2,521.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,747.5	5,657.6
	Нийт хөрөнгийн дүн	8,132.8	8,178.9
	Нийт өр төлбөрийн дүн	941.2	1,107.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,191.5	7,071.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,132.8	8,178.9
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,405.2	2,348.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,528.5	2,482.0
	Үйл ажиллагааны үр дүн	(123.3)	(133.5)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(123.3)	(133.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,328.3	7,218.4
	Тайлант оны үр дүн	(123.3)	(133.5)
	Эцсийн үлдэгдэл	7,205.0	7,071.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,035.1	2,646.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,976.1	2,192.5
	Үйл ажиллагааны ЦМГ	102.1	527.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(153.8)	(172.2)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(51.7)	(355.4)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,787.4	1,735.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,735.7	2,091.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,380.7	2,291.1
	Урсгал зардал	2,190.7	2,092.5
	Хөрөнгийн зардал	90.0	98.6
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,730.7	2,646.5
	Улсын төсвөөс санхүүжих		3.2
	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		503.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		2,139.5

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургууль нь олон улсын стандартад нийцсэн чанартай боловсрол, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг нээлттэй сургууль болох эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 167 мэдээллээс 2 мэдээллийг хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 2,341,733.4 мянган төгрөгийн 87 мэдээлэл, зарлагын 360,914.8 мянган төгрөгийн 22 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш 173,193.9 мянган төгрөгийн 11 мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хэтрэлт, хэмнэлт, төсөвт орсон өөрчлөлт, хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн мэдээлэл зэргийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулсан байна. Хугацаа хоцорсон 2 мэдээлэл нь хугацаандаа оруулсан боловч засвар хийгдэж хоцорсон төлөвт орсон, мөн нийт оруулбал зохих мэдээллийг хоцорсон мэдээлэлд харьцуулахад бага хэмжээний алдаа учир зөрчилд аваагүй болно.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 182,214.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илрүүлснээс 102.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 182,111.2 мянган төгрөгийн алдаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

Зөвлөмж

Татаас санхүүжилтийн авлага 182,111.2 мянган төгрөгийг АШУҮИС болон Боловсрол шинжлэх ухааны яамтай тооцоо нийлээгүй, авлага барагдуулах арга хэмжээг авч ажилласан ч үр дүнд хүрээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаад зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	/сая төгрөгөөр/										
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	ТШЗ	2	182.2	1	0.1						1	182.1
2	Төсөл, хөтөлбөр											
3	ЗГТС											
4	ТТЗ											
5	ТЕЗ											
	НИЙТ	3	463.4	1	0.1						1	182.1